

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан.

Аудитын код: САГ-2026/07/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 51-261628 Цахим хаяг: Battsetsegp@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхбулган Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.4.1 Мөнгөн хөрөнгө	15
3.4.2 Авлага.....	15
3.4.3 Урьдчилгаа	16
3.4.4 Бараа материал.....	16
3.4.5 Үндсэн хөрөнгө.....	17
3.4.6 Өр төлбөр.....	18
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо.....	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.5.1 Төсвийн төлөвлөлт	19
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	19
3.5.3 Нэмэлт төсөв.....	20
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	20
4 АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Завсрын аудитын талаар.....	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Харьяа байгууллагууд	24
5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	24
5.2.1 Албан шаардлага	24
5.2.2 Зөвлөмж	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МЭАЦТЛ	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лобартори
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
МЭЭСБУЛ	Мал Эмнэлгийн Эмийн Сорьц Баталгаажуулалтын Улсын Лаборатори
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УМЭАЦТЛ	Улсын Мал Эмнэлэг, Ариун Цэврийн Төв Лаборатори
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын Төсөвт Үйлдвэрийн Газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГБ	Шууд гэрээ байгуулах



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 794
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүйн улмаас тайлант онд 13,913.6 сая төгрөгийн авлага, 31,589.3 сая төгрөгийн өглөгтэй ажилласан, батлагдсан төсвийг хуваарилахдаа Төсвийн шууд захирагч бүрээр албажуулж, баталгаажуулж төсвийн захирагч нарт хүргүүлээгүй, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн 4,753.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 6.6.1, 7 дугаар зүйлийн 7.3, төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 22 дугаар зүйлийн 22.6.6, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

ХХААХҮС-ын санаачилгаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 13 дахь тусгай чиг үүргийн байгууллагын хувьд мал эмнэлгийн салбарт анх удаа “Команд штабын сургууль”-ийг 2025 онд ОБЕГ-ын удирдлага дор зохион байгуулж, штабын дадлага сургуульд мал эмнэлгийн байгууллагын 1037, нийт 1344 албан хаагч хамрагдан амжилттай оролцов.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 153 дугаар тогтоолоор “Мал эмнэлэгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” УТҮГ-ыг “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” УТҮГазарт нэгтгэн “Улсын мал эмнэлэг, ариун цэвэр, эмийн сорилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гарч, нэгтгэх, шилжүүлэх ажлыг ХХААХҮСайдад даалгасан ажил удаашралтай байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Салбарын үндсэн үйл ажиллагаатай холбоотой тухайлбал жил бүр давтагдах шинж чанартай дархлаажуулалтыг зохион байгуулах, тарилгын үйлчилгээний хөлс олгох гэх мэт байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг харьяа 22 байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансруу шилжүүлж, төсвийн үндсэн зарчмыг алдагдуулж байгаагаас тайлант онд их хэмжээний өр авлага үүсч давхардсан дүнгээр 25,353.7 сая төгрөгийн авлага, 43,029.4 сая төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.

Бусад асуудал

Мал эмнэлгийн ерөнхий газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлсэн боловч тодруулга тайлбар дутуу, холбогдох баримт мэдээллийг гаргаж өгөх албан хаагчийг тус байгууллагын тооцооны нягтлан бодогчийн томилсон зэрэг нь аудит хийхэд тодорхой хэмжээнд бэрхшээлтэй байлаа.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,722,788.1	35,488,969.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,524,727.2	-
33	АВЛАГА	2,077,942.8	13,913,638.6
34	УРЬДЧИЛГАА	205,821.6	26,092.5
35	БАРАА МАТЕРИАЛ	26,914,296.5	21,549,238.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	33,961,919.1	42,759,546.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,961,919.1	42,759,546.1
39200	Биет хөрөнгө	30,757,219.1	39,547,578.7
39300	Биет бус хөрөнгө	3,204,700.0	3,211,967.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	74,684,707.2	78,248,515.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,538,796.1	31,589,329.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,538,796.1	31,589,329.4
41300	Өглөг	11,538,796.1	31,589,329.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	63,145,911.1	46,659,186.4
51	Засгийн газрын хувь оролцоо	63,145,911.1	46,659,186.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	9,891,053.6	9,891,053.6
51200	Хуримтлагдсан үр дүн	49,143,579.9	32,687,393.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,111,277.6	4,080,739.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	74,684,707.2	78,248,515.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	132,048,213.7	108,876,159.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,837,341.3	108,876,159.6
120	Тусламжийн орлого	-	91,918,042.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	121,210,872.5	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	119,606,530.5	125,240,989.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,606,530.5	125,240,989.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,141,388.0	122,707,300.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,198,346.4	35,909,239.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,954,856.3	4,568,136.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,137,993.5	1,418,985.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,572,409.2	1,525,927.0
2105	Нормативт зардал	28,813,926.3	30,872,704.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	501,912.3	564,926.6
2107	Томилолт, зочны зардал	1,532,920.1	757,755.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,298,404.1	39,882,960.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,130,619.9	7,206,666.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,465,142.5	2,533,688.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	12,441,683.3	(16,364,829.6)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,764.3	118,116.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	12,416,919.0	(16,482,945.6)

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	134,325,660.0	105,040,078.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,872,875.8	105,040,078.3
120	Нийтлэг татварын бус орлого	12,872,875.8	13,135,922.7
122	Тусламжийн орлого	-	91,904,155.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	121,452,784.2	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	121,617,685.5	115,952,581.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	121,617,685.5	115,952,581.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,041,019.9	101,358,613.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,238,792.0	35,876,543.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,950,398.1	4,553,863.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,149,476.4	1,458,837.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,241,965.7	809,069.8
2105	Нормативт зардал	29,728,104.5	8,727,780.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,217,237.0	1,834,374.0
2107	Томилолт, зочны зардал	1,532,920.1	709,652.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,681,560.7	47,081,574.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,565.3	306,918.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,576,665.2	14,593,968.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	12,707,975.0	(10,912,503.5)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,191,717.8	612,223.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,191,717.8	612,223.6
2200	Дотоод эх үүсвэрээр	1,191,717.8	612,223.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,191,717.8)	(612,223.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	11,516,257.2	(11,524,727.2)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,470.0	11,524,727.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,524,727.2	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,510,257.2		50,510,257.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,574.9		3,574.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,513,832.1		50,513,832.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	215,160.0		215,160.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	12,416,919.0		12,416,919.0
6	Тайлант үеийн үр дүн	63,145,911.1		63,145,911.1
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,145,911.1		63,145,911.1
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	63,172,670.3		63,172,670.3
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(30,263.0)		(30,263.0)
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(275.3)		(275.3)
11	Тайлант үеийн үр дүн	(16,482,945.6)		(16,482,945.6)
12	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,659,186.3		46,659,186.3

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	104,716,657,200.00	79,089,032,695.81	25,627,624,504.19	75.5
Татварын бус орлого	104,716,657,200.00	79,089,032,695.81	25,627,624,504.19	75.5
Нийтлэг татварын бус орлого	1,041,094,400.00	1,688,774,259.00	(647,679,859.00)	162.2
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,041,094,400.00	1,685,270,559.00	(644,176,159.00)	161.9
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	3,503,700.00	(3,503,700.00)	-
Тусламжийн орлого	103,675,562,800.00	77,400,258,436.81	26,275,304,363.19	74.7
Төсвөөс санхүүжих	103,675,562,800.00	77,400,258,436.81	26,275,304,363.19	74.7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,716,657,200.00	78,536,846,695.96	26,179,810,504.04	75.0
УРСГАЛ ЗАРДАЛ	104,716,657,200.00	78,536,846,695.96	26,179,810,504.04	75.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,898,491,200.00	77,102,805,313.51	25,795,685,886.49	74.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,000,252,300.00	34,441,864,208.54	558,388,091.46	98.4
Үндсэн цалин	20,547,252,500.00	19,567,241,467.72	980,011,032.28	95.2
Нэмэгдэл	9,608,750,300.00	9,517,563,010.97	91,187,289.03	99.1
Унаа хоолны хөнгөлөлт	2,785,566,400.00	3,335,496,924.30	(549,930,524.30)	119.7
Урамшуулал	2,058,683,100.00	2,021,562,805.55	37,120,294.45	98.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,448,424,100.00	4,352,794,919.05	95,629,180.95	97.9
Тэтгэврийн даатгал	3,028,853,600.00	2,975,642,133.89	53,211,466.11	98.2
Тэтгэмжийн даатгал	356,732,600.00	342,791,445.77	13,941,154.23	96.1
ҮОМШӨ-ний даатгал	193,300,500.00	204,685,941.19	(11,385,441.19)	105.9
Ажилгүйдлийн даатгал	175,402,200.00	170,216,814.13	5,185,385.87	97.0
Эрүүл мэндийн даатгал	694,135,200.00	659,458,584.07	34,676,615.93	95.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,522,995,000.00	1,453,546,369.00	69,448,631.00	95.4
Гэрэл, цахилгаан	425,370,100.00	430,415,545.56	(5,045,445.56)	101.2
Түлш, халаалт	831,553,600.00	805,084,390.42	26,469,209.58	96.8
Цэвэр, бохир ус	110,603,000.00	72,698,580.88	37,904,419.12	65.7
Байрны түрээс	155,468,300.00	145,347,852.14	10,120,447.86	93.5
Хангамж, бараа материалын зардал	680,907,200.00	596,360,363.89	84,546,836.11	87.6
Бичиг хэрэг	123,516,400.00	96,387,161.00	27,129,239.00	78.0
Тээвэр, шатахуун	289,900,900.00	280,775,624.00	9,125,276.00	96.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,394,500.00	74,848,880.89	15,545,619.11	82.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,405,700.00	11,208,860.00	8,196,840.00	57.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	157,689,700.00	133,139,838.00	25,549,862.00	84.4
Нормативт зардал	18,840,851,100.00	5,303,788,986.39	13,537,062,113.61	28.2
Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	18,828,150,500.00	5,295,772,902.39	13,532,377,597.61	28.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,700,600.00	8,016,084.00	4,684,516.00	63.1
Эд хогшил, урсгал засварын зардал	2,011,783,200.00	1,795,444,581.14	216,338,618.86	89.2
Багаж, техник, хэрэгсэл	927,220,700.00	834,974,633.60	92,246,066.40	90.1
Тавилга	13,000,000.00	12,787,900.00	212,100.00	98.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	504,063,900.00	456,575,330.00	47,488,570.00	90.6
Урсгал засвар	567,498,600.00	491,106,717.54	76,391,882.46	86.5
Томиллолт, зочны зардал	633,725,700.00	584,090,342.00	49,635,358.00	92.2
Дотоод албан томиллолт	633,725,700.00	584,090,342.00	49,635,358.00	92.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,481,016,200.00	28,353,859,683.50	11,127,156,516.50	71.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,056,801,000.00	28,106,910,983.00	10,949,890,017.00	72.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,873,900.00	17,919,000.00	19,954,900.00	47.3
Даатгалын үйлчилгээ	56,519,700.00	31,117,841.50	25,401,858.50	55.1
Тээврийн хэрэгслийн татвар	39,236,100.00	19,200,620.00	20,035,480.00	48.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,667,800.00	2,435,640.00	10,232,160.00	19.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,726,300.00	163,082,666.00	87,643,634.00	65.0
Газрын төлбөр	27,191,400.00	13,192,933.00	13,998,467.00	48.5

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	278,536,400.00	221,055,860.00	57,480,540.00	79.4
Бараа үйлчилгээний бусад зардал	199,435,800.00	163,367,429.00	36,068,371.00	81.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,100,600.00	57,688,431.00	21,412,169.00	72.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,818,166,000.00	1,434,041,382.45	384,124,617.55	78.9
Бусад урсгал шилжүүлэг	1,818,166,000.00	1,434,041,382.45	384,124,617.55	78.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	116,194,800.00	71,366,650.00	44,828,150.00	61.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	763,994,300.00	665,349,421.50	98,644,878.50	87.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	838,814,800.00	636,404,940.95	202,409,859.05	75.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,162,100.00	60,920,370.00	38,241,730.00	61.4
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	552,185,999.85	(552,185,999.85)	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(552,185,999.85)	552,185,999.85	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(552,185,999.85)	552,185,999.85	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,440,248,500.02	(11,440,248,500.02)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	24	24	-	100.0
Төсвийн байгууллага	24	24	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,307	1,189	(118)	90.9
Удирдах ажилтан	25	25	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,212	1,164	(48)	96.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,307	1,189	(118)	90.9
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	948	876	(72)	92.4
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	359	313	(46)	87.2

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		26,330,830,796.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		26,330,830,796.06
122	Тусламжийн орлого		26,330,830,796.06
1221	Хандив тусламж /дотоод/		26,330,830,796.06
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		26,330,830,796.06
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		231,875,213.64
350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,116,221,302.54
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,196,295,704.88
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		786,438,575.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		25,889,147,823.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ		25,833,681,596.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		25,831,131,596.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,434,679,400.45
210101	Үндсэн цалин		56,557,197.14
210102	Нэмэгдэл		1,083,280,724.26
210104	Урамшуулал		248,233,563.00
210105	Гэрээт ажлын хөлс		46,607,916.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		201,068,417.77
210201	Тэтгэврийн даатгал		153,654,507.46
210202	Тэтгэмжийн даатгал		11,051,699.55
210203	ҮОМШӨ-ний даатгал		11,099,642.26
210204	Ажилгүйдлийн даатгал		4,334,401.61
210205	Эрүүл мэндийн даатгал		20,928,166.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		5,892,772.38
210301	Гэрэл, цахилгаан		5,792,772.38
210302	Түлш, халаалт		100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		213,907,644.86
210401	Бичиг хэрэг		6,415,988.00
210402	Тээвэр, шатахуун		175,854,726.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,826,698.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		28,810,232.00
2105	Нормативт зардал		3,467,905,743.20
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		3,427,500,443.20
210502	Хоол, хүнс		40,405,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		510,392,156.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		341,782,836.00
210602	Тавилга		47,990,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		58,786,600.00
210604	Урсгал засвар		61,832,720.00
2107	Томилолт, зочны зардал		126,048,320.00
210701	Гадаад албан томилолт		16,099,320.00
210702	Дотоод албан томилолт		109,949,000.00

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,767,777,771.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		19,767,777,771.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		103,459,370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		88,107,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		15,352,170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,550,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,550,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		55,466,227.00
2200	Дотоод эх үүсвэрээр		55,466,227.00
221001	Их засвар		55,466,227.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		441,682,972.90
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		441,682,972.90
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(441,682,972.90)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мал эмнэлгийн ерөнхий газар нь эрхэм зорилгоо “Мал эмнэлгийн салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Мал амьтны өвчний тохиолдол, тархалт, оношилгоо, тандалтын мэдээллийг бүртгэх, боловсруулах, тархвар зүйн судалгаа, тооцоо, дүн шинжилгээ хийх, программ хангамж, системийн хөгжүүлэлтийн асуудлыг хариуцан, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөх, мэдээ мэдээллээр хангах;
- Мал амьтны гоц халдварт, халдварт, зооноз, шимэгчлэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилт, тавлаг байдлыг хангах, эм био бэлдмэлийн үйлдвэрлэл, хэрэглээний стандартыг хангуулах;
- Мал, амьтны өвчингүй тайван байдал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, мал эмнэлгийн үйлчилгээг баталгаажуулах, хянах, үнэлэх, хүний нөөцийг чадавхжуулах, итгэмжлэх, экспорт, импортын дэмжлэг үзүүлэх, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн аудит хийх, олон нийтийн мэдээ, мэдээллээр хангах, олон талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн болон салбарын санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Төрийн албаны тухай хуулиуд болон түүнийг дагалдан гарсан заавар, журам, “Төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын дагуу мал, амьтны болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах, малын өвчин эмгэгтэй тэмцэх, хүн ам, эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдал, худалдааны чөлөөт байдлыг баталгаажуулах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Дээрх үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх бодлогыг оновчтой төлөвлөж, улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж хэрэгжилтийг зохион байгуулах;
- Мал, амьтны шинэ болон дахин сэргэж буй, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайгаас шалтгаалсан өвчин эмгэгийн шалтгаан, нөхцөлийг судалж өвчинтэй тэмцэх арга хэмжээг боловсруулах, судалгаа шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Өвчингүй тайван бүсийг тогтоож, мал эмнэлгийн олон улсын гэрээ хэлцэл, ариун цэвэр, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, худалдааны чөлөөт байдлыг дэмжих;

- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах, баталгаажуулах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах;
- Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бий болгох, эрт илрүүлэлт, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн тогтолцоог бүрдүүлж, бүсчлэн хөгжүүлж, чадавхыг дээшлүүлж, үндэсний болон бүс нутгийн лавлагаа лабораторийн түвшинд хүрэх;
- Мал, амьтны эмийн үндэсний үйлдвэрлэлийн шинэчлэл хийж, олон улсын жишигт нийцүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн үлдэгдлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эмийн худалдаа, үйлчилгээний бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх;
- Мал эмнэлгийн гадаад харилцааг өргөжүүлэх, мал эмнэлгийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангуулах;
- Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор эрсдэлд суурилсан, мэргэшсэн, чадварлаг мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Мал эмнэлгийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, дотоод, гадаадын сайн туршлагыг нэвтрүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Мал эмнэлгийн салбар байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын төрийн захиргааны удирдлагын менежментийг төлөвшүүлж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-г нэвтрүүлэх зэрэг болно.

Тайлант хугацаанд агентлагийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Малчны тухай хууль;
- Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль;
- Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжиж үнийг зохистой түвшинд тогтворжуулах зорилгоор импортоор оруулах мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай;
- Улсын Их Хурлын 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 73 дугаар тогтоол;
- Улсын Их Хурлын 2025 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоол /Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам/;
- Засгийн Газрын 2025 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 46 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 56 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 66 дугаар тогтоол;

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Засгийн Газрын 2025 оны “Техникийн зохицуулалт шинэчлэн батлах тухай” 69 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 108 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай” 190 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

МЭЭГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

МЭЭГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,563.8 сая төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,524,727.2	-	(11,524,727.2)
Авлага	2,077,942.8	13,913,638.6	11,835,695.8
Урьдчилгаа	205,821.6	26,092.5	(179,729.1)
Бараа материал	26,914,296.5	21,549,238.6	(5,365,057.9)
Үндсэн хөрөнгө	33,961,919.1	42,759,546.1	8,797,627.0
Нийт хөрөнгө	74,684,707.2	78,248,515.8	3,563,808.6
Өр төлбөр	11,538,796.1	31,589,329.4	20,050,533.3
Засгийн газрын хувь оролцоо	63,145,911.1	46,659,186.4	(16,486,724.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	74,684,707.2	78,248,515.8	3,563,808.6

Эх сурвалж: МЭЭГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 11,524.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг	11,524,727.2	-	(11,524,727.2)
Төрийн сангийн харилцах	8,820.0	-	(8,820.0)
Арилжааны банк дахь харилцах	11,515,907.2	-	(11,515,737.2)
Дүн	11,524,727.2	-	(11,524,727.2)

Эх сурвалж: МЭЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 11,524.7 сая төгрөгөөр буурсан нь Арилжааны банкны үлдэгдэлд ОХУ-аас Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины худалдан авалтыг хийж, төлбөрийг 2024 онд Сангийн ямаар дамжуулж БНХАУ-ын юаниар шилжүүлсэн нь ОХУ-ын улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж гүйлгээ буцсаныг оны эцэст арилжааны банканд байршуулсан мөнгөн хөрөнгийг тайлант онд төлж барагдуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- Төсвийг зохистой удирдаагүй Архангай аймгийн МЭГ 19.5 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн МЭГ 15.9 сая төгрөг, Булган аймгийн МЭГ 7.0 сая төгрөг, Дорноговь аймгийн МЭГ 8.2 сая төгрөг, Орхон аймгийн МЭГ 8.9 сая төгрөг, Төв аймгийн МЭГ 24.7 сая төгрөг, Нийслэлийн МЭГ 7.0 сая төгрөг, МЭЕГ 55.9 сая төгрөг, МЭЕГ 1.2 сая төгрөг;
- Томилолтоор ажилласан албан хаагчдад унаа хоолны мөнгө давхардуулж олгосон Баянхонгор аймгийн МЭГ 0.6 сая төгрөг, Булган аймгийн МЭГ 1.2 сая төгрөг, Дорнод аймгийн МЭГ 0.1 сая төгрөг, Дорноговь аймгийн МЭГ 0.3 сая төгрөг, Завхан аймгийн МЭГ 2.9 сая төгрөг, УМЭАЦТЛ 0.6 сая төгрөг, МЭЭСБУЛ 0.6 сая төгрөг;
- Цалин хөлс зөрүүтэй олгосон МЭЭСБУЛ 4.1 сая төгрөг;
- Тушаал шийдвэргүй илүү цагийн хөлс олгосон Булган аймгийн МЭГ 18.1 сая төгрөг, Дорноговь аймгийн МЭГ 0.7 сая төгрөг;
- Томилолтын зардал давхардуулан, илүү олгосон Булган аймгийн МЭГ 0.9 сая төгрөг, МЭЕГ 3.1 сая төгрөг;
- Томилолтын зардалтай холбоотой зөрчил МЭЕГ 257.4 сая төгрөг;
- Үр дүнгийн урамшуулал илүү тооцож олгосон Булган аймгийн МЭГ 1.7 сая төгрөг;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу Булган аймгийн МЭГ 2.3 сая төгрөг;
- Илүү цалин олгосон Дархан уул аймгийн МЭГ 0.8 сая төгрөг;
- 5 жил тутамд олгодог нэг удаагийн тэтгэмжийг хугацаа болоогүй албан хаагчид олгосон Завхан аймгийн МЭГ 8.2 сая төгрөг;
- Балансын урамшуулал олгосон Төв аймгийн МЭГ 3.4 сая төгрөг, Ховд аймгийн МЭГ 1.5 сая төгрөг, МЭЭСБУЛ 2.8 сая төгрөг;
- Халагдсан ажилтанд цалин олгосон Ховд аймгийн МЭГ 7.4 сая төгрөг.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 13,913.6 сая төгрөг болж, өмнөх оноос 11,835.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	10,840.2	9,608.1	(1,232.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	113,124.7	11,807,911.5	11,694,786.8
Байгууллагаас авах авлага	1,796,507.0	1,954,735.3	158,228.3

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хувь хүмүүсээс авах авлага	157,470.8	141,383.7	(16,087.1)
Дүн	2,077,942.7	13,913,638.6	11,835,695.9

Эх сурвалж: МЭЭГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 84.8 хувийг татаас санхүүжилтийн, 14.0 хувийг байгууллагаас авах, 1.0 хувийг хувь хүмүүсээс авах авлага тус тус эзэлж байна.

Татаас санхүүжилтийн авлага дансанд УМЭАЦТЛ-ийн 316.6 сая төгрөг, МЭЭСБУЛ-ийн 2.7 сая төгрөг, нийслэлийн МЭГ-ын 436.6 сая төгрөг, бусад 21 аймгийн МЭГ-ын МЭҮН-д олгох мал эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн 11,052.0 сая төгрөг бүртгэлтэй байна.

Байгууллагаас авах авлагын үлдэгдэл 158.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь оны эцэст Сэлэнгэ аймгийн МЭГ аймгийн ЗДТГ-аас авах 124.1 сая төгрөгийг авлагыг бүртгэсэн нь голлон нөлөөлж байна.

Аудитын илрүүлэлт

- Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд авлага үүсгэсэн, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд зөрүүтэй бүртгэсэн Дундговь МЭГазар 2.1 сая төгрөг;
- Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон дүнг буруутай этгээдээс гаргуулаагүй МЭЭГ 44.5 сая төгрөг.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 26.1 сая төгрөг болж, 179.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	205,821.6	26,092.5	(179,729.1)
Дүн	205,821.6	26,092.5	(179,729.1)

Эх сурвалж: МЭЭГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 179.7 сая төгрөгөөр буурсан нь МЭЭГ болон Биокомбанит ТӨХХК -ийн хооронд "Тусгай зориулалт бүхий хөргүүрт 2023, 2024 онд авсан гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин хадгалах " 2024/135 дугаар бүхий гэрээ байгуулан 195.6 сая төгрөгийг урьдчилж төлсөн байсныг тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- 1 жилийн хугацаатай гэрээний хавсралтыг 2 жилээр байгуулж он дамжуулж бүртгэсэн зөрчил МЭЭГ 195.6 сая төгрөг.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 21,549.2 сая төгрөг болж, өмнөх оноос 5,365.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	23,118,983.0	17,376,115.7	(5,742,867.3)
Тусгай зориулалттай материал	1,595,298.6	1,558,977.6	(36,321.0)
Эм боох материал	21,523,684.4	15,817,138.1	(5,706,546.3)
Бэлэн бүтээгдэхүүн		876.7	876.7
Хангамжийн материал	3,723,434.6	4,129,749.2	406,314.6
Бичиг хэргийн материал	174,182.2	146,952.8	(27,229.4)
Аж ахуйн материал	831,162.9	1,126,880.6	295,717.7
Сэлбэг хэрэгсэл	65,155.6	60,122.5	5,033.1
Түлш, шатах тослох материал	96,880.4	46,203.6	(50,676.8)

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Барилгын засварын материал	33,586.5	26,880.6	(6,705.9)
Бусад хангамжийн материал	2,522,467.0	2,722,709.1	200,242.1
Мал амьтад	71,878.9	42,497.0	(29,381.9)
Дүн	26,914,296.5	21,549,238.6	5,365,057.9

Эх сурвалж: МЭЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 5,365.1 сая төгрөгөөр буурахад эм боох материал 5,706.5 сая төгрөг, түлш шатах тослох материал 50.6 сая төгрөг, тусгай зориулалтын материал 36.3 сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материалын үлдэгдлийн 15,817.1 сая төгрөг буюу 73.4 хувийг эм боох материал, 1,558.9 сая төгрөг буюу 7.2 хувийг тусгай зориулалтын материал, 4,129.7 сая төгрөг буюу 19.2 хувийг хангамжийн материал, 42.9 сая төгрөг буюу 0.2 хувийг мал, амьтадын үлдэгдэл тус тус эзэлж байна. Бараа материалын үлдэгдлийн 73.4 хувийг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин эзэлж байна. Үүнд: Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 7,199.1 сая төгрөг, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэн вакцин 1,335.1 сая төгрөг, үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх вакцин 1,093.5 сая төгрөг тус тус голлох дүнг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа материалыг анхан шатны баримтын бүрдэл дутуу бүртгэсэн Булган аймгийн МЭГ 2.3 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн МЭГ 43.5 сая төгрөг;
- Бараа материалын дансны үлдэгдэл буруу илэрхийлсэн Сүхбаатар аймгийн МЭГ, УМЭАЦТЛ 393.6 сая төгрөг;
- Хугацаа дууссан эм бэлдмэл бүртгэлтэй Ховд аймгийн МЭГ, МЭЕГ 349.3 сая төгрөг;
- Хөвсгөл аймгийн МЭГ Мал амьтад дансанд буй малын үнийг зах зээлийн үнээс хэт доогуур үнэлж бүртгэсэн;
- Нийслэлийн МЭГ бараа материалын шаардах хуудсыг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулдаггүй;
- Бараа материалд бүртгэлтэй 40 нэр төрлийн гэрчилгээг тооцоо нийлж баталгаажуулаагүй МЭЕГ.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 42,759.5 сая төгрөг болж, өмнөх оноос 8,797.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	30,757,219.1	39,547,578.6	8,790,359.5
Барилга, байгууламж, орон сууц	13,673,252.8	20,100,200.0	6,426,947.1
Авто-тээврийн хэрэгсэл	6,296,721.2	6,320,798.4	24,077.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,817,025.7	7,630,574.5	813,548.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	777,390.3	2,144,640.8	1,367,250.5
Бусад үндсэн хөрөнгө	3,192,829.1	3,351,364.9	158,535.8
Биет бус хөрөнгө	3,204,700.0	3,211,967.5	7,267.5
Программ хангамж	421,432.8	448,341.5	26,908.7
Бусад биет бус хөрөнгө	2,783,267.2	2,763,626.0	(19,641.2)
Дүн	33,961,919.1	42,759,546.1	8,797,627.1

Эх сурвалж: МЭЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө данс төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 739.2 сая төгрөг, дээд шатны болон бусад байгууллагаас балансаас баланст шилжүүлэн авсан 8,322.8 сая төгрөг, бусад 5,235.8 сая төгрөг, нийт 15,437.9 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын шийдвэрээр акталж данснаас хассан 1,092.8 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 69.7 сая төгрөг, бусад 3,449.1 сая төгрөг, дахин үнэлгээний хасагдуулга 711.1 нийт 5,322.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл тайлант жилийн байгуулсан элэгдэл 6,417.2 сая төгрөг, бусад элэгдэл 150.9 сая төгрөгөөр нэмэгдэж, акталж данснаас хассан хөрөнгийн элэгдэл 5,250.2 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгийн цэвэр үлдэгдлийг 42,759.5 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн газарт олон улсын стандартад нийцсэн мал эмнэлгийн итгэмжлэгдсэн биоаюулгүйн 2 дугаар зэрэглэлийн лабораторийг ашиглалтад оруулж 3,016.6 сая төгрөгийн өртгөөр балансад бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн МЭГ нь жилийн эцсийн эд хөрөнгийг 80.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Булган аймгийн МЭГ нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 46.6 сая төгрөгийн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй;
- Эргэлтийн хөрөнгө дутагдсан Говьсүмбэр аймгийн МЭГ 0.2 сая төгрөг;
- Говьсүмбэр аймгийн МЭГ элэгдэл буруу тооцоолсон 5.6 сая төгрөг;
- Нийслэлийн МЭГ үндсэн хөрөнгийн тооллого хийхдээ тооцоо бодсон акт үйлдээгүй, 1.671.9 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацаа сунгаагүй, үнэ шинэчлэн тогтоогоогүй;
- УМЭАЦТЛ жилийн эцсийн эд хөрөнгийг 461.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 31,589.3 сая төгрөг болж, өмнөх оноос 20,050.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өр төлбөр	9,880.5	60,649.0	50,678.5
Бараа үйлчилгээний зардлын өр төлбөр	1,038.4	400,839.6	399,801.2
Байгууллагад төлөх өр төлбөр	11,522,137.6	30,986,342.4	19,464,204.8
Хувь хүмүүст төлөх өр төлбөр	5,739.6	141,498.4	135,758.8
Дүн	11,538,796.1	31,589,329.4	20,050,533.3

Эх сурвалж: МЭЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 20,050.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Бүгд найрамдах ТУРК улсын “Долвет биотехнологи хувьцаат компани”-иас авсан малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 7.7 сая тун вакцины үнэ болох 7,745.1 сая төгрөг, Иордани улсын “Жовак” ХХК-иас авсан малын гол халдварт бол малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх 10.4 сая тун вакцины үнэ 1,150.6 сая төгрөг, мөн дотоодын худалдан авалтаас Грийн химисти ХХК-аас авсан мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуурын төлбөр 133.4 сая төгрөг, “Монголиан ветеринари кооператив Дундын хоршоо” ХХК-аас авсан мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуурын 814.6 сая төгрөгийн өр төлбөрийг тус тус тайлант онд багтаан шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Баян-Өлгий аймгийн МЭГ нь 511.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Өмнөговь аймгийн МЭГ 4.5 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;
- Сүхбаатар аймгийн МЭГ газар төсвийг зохистой удирдаагүйгээс 81.2 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 46,659.2 сая төгрөг болж, өмнөх оноос 16,486.7 сая төгрөгөөр буурсан байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	9,891,053.6	9,891,053.6	-
Хуримтлагдсан үр дүн	49,143,579.9	32,687,393.5	(16,456,186.4)
Өмнөх үеийн үр дүн	36,726,660.9	49,170,339.1	12,443,678.2
Тайлант үеийн үр дүн	12,416,919.0	(16,482,945.6)	(4,066,026.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,111,277.6	4,080,739.2	(30,538.4)
Дүн	63,145,911.1	46,659,186.4	(16,486,724.7)

Эх сурвалж: МЭЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант жилийн үр дүн 16,482.9 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 30.5 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

МЭЕГ-ын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 139,638.8 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1041.1 сая төгрөг, нийт зарлагыг 140,679.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 64,951.7 сая төгрөгөөр бууруулж, 105,989.7 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан төсвийг 1,273.1 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 15 арга хэмжээг улсын төсвөөс 103,675.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,041.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 78,098.7 сая төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогоос 1,688.7 сая төгрөг, нийт 79,787.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, бараа, ажил, үйлчилгээний зардалд 77,102.8 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 1,434.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 552.2 сая төгрөгийг өглөгт тооцож улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 698.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 78,536.8 сая төгрөг буюу 75 хувьтай байгаа нь мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардал 24,328.5 сая төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 11,926.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
708010	Мал аж ахуйг хөгжүүлэх	60,509,164.1	36,180,579.1	(24,328,585.0)	59.8
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,406,221.1	2,348,377.8	57,843.2	97.6
802190	Харуул, хамгаалалтын зардал	13,828.9	13,828.9	-	100.0
802270	Лабораторийн итгэмжлэл	7,941.3	6,819.1	(1,122.2)	85.9
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	6,547.6	400.0	(6,147.6)	6.1
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	88,728.0	67,246.8	(21,481.1)	75.8
825040	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	7,069,103.1	4,106,122.8	(2,962,980.3)	58.1

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

825060	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	38,530,828.8	26,604,545.1	(11,926,283.7)	69.0
825070	Малыг архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх	6,438,059.5	269,430.2	(6,168,629.3)	4.2
825080	Малын өвчний лабораторийн оношилгоо, шинжилгээ	1,895,500.0	902,205.9	(993,294.1)	47.6
825480	Мал, амьтан эрүүлжүүлэх	4,052,405.8	1,861,602.3	(2,190,803.5)	45.9
708050	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	43,849,793.5	42,178,995.8	(1,670,797.7)	96.2
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	41,935,642.5	40,663,004.2	(1,272,638.3)	97.0
801030	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	82,532.6	76,395.0	(6,137.6)	92.6
802270	Лабораторийн итгэмжлэл	20,000.00	5,955.2	(14,044.8)	29.8
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,811,618.4	1,433,641.4	(377,977.0)	79.1
708060	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ	357,699.6	177,271.8	(180,427.8)	49.6
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	357,699.6	177,271.8	(180,427.8)	49.6
Нийт дүн		104,716,657.2	78,536,846.7	(26,179,810.5)	75.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлогоос 231.9 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс 12,116.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 13,196.3 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон бусад нэмэлт орлогын эх үүсвэрээс 786.4 сая төгрөг, нийт 26,330.8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Үүнээс бараа ажил, үйлчилгээний зардалд 25,831.1 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 2.5 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 55.5 сая төгрөгийг зарцуулж, 441.7 сая төгрөгийг улс орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ХХААХҮС-ын 2025 оны 01 дүгээр сарын А/17 дугаар тушаалаар анх баталсан байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/50 дугаар тушаалаар нийт 17,812.2 сая төгрөгийн 55 бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж баталсан байна. Гүйцэтгэлээр 16,898.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 12,137.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулах аргаар, 4,761.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 бараа, ажил үйлчилгээг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4 АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг иж бүрэн байршуулах, төсвийн зардлыг хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, дээд шатны байгууллагад хянуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитор Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг Аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/283 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 119,606.5 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 1,196.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган аймгийн МЭГ газар нь их хэмжээний бараа нөөцөлсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган аймгийн МЭГ хэвлэмэл хуудас болон үнэт цаасны тайлан гаргаагүй;

- Булган аймгийн МЭГ нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 46.6 сая төгрөгийн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй;
- Говьсүмбэр аймгийн МЭГ нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 153.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгааг арга хэмжээ аваагүй;
- Дотоод журмыг шинэчлэн батлахдаа хамт олны хурлаар хэлэлцүүлээгүй Говьсүмбэр аймгийн МЭГ;
- Худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлэл байршуулаагүй Орхон аймгийн МЭГ;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагдаагүй ажил гүйцэтгэсэн Төв аймгийн МЭГ 20.0 сая төгрөг, МЭЕГ 229.5 сая төгрөг;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа 1 төрлийн ажил гүйлгээг гэрээ шууд байгуулах аргыг ашиглан олон салгаж худалдан авахаар төлөвлөсөн, тус тушаалын хэрэгжилт хангалтгүй МЭЕГ 226.0 сая, Төсөвт өртгийг хувааж гэрээ байгуулсан МЭЕГ 148.9 сая төгрөг;
- Байгууллагын хэрэгцээнд ашиглаж буй автомашинуудыг цэнхэр өнгийн улсын дугаартай болгоогүй Ховд аймгийн МЭГ, УМЭАЦТЛ 3 тээврийн хэрэгсэл;
- Нийслэлийн МЭГ худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй 39.0 сая төгрөг.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллийг хугацаандаа оруулж ажилласан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 02/275 дугаар албан бичгээр харьяа байгууллагуудын Шилэн дансны тайлангийн нэгтгэлийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай зарим талаар нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

- Булган аймгийн МЭГ нь ил тод мэдээлэх файлын хавсралт дутуу оруулсан, бөөн дүнгээр мэдээлсэн;
- Хуулийн хэрэгжилт хангаж ажиллаагүй Дорнод аймгийн МЭГ 749.6 сая төгрөг, Орхон аймгийн МЭГ 8.7 сая төгрөг, Увс аймгийн МЭГ 6,800.7 сая төгрөг, Нийслэлийн МЭГ 2,554.4 сая төгрөг, МЭЕГ 2,021.4 сая төгрөг;
- Дорноговь аймгийн МЭГ шилэн дансны хугацаа хоцролтын хэрэгжилт 55 хувь, 14 тушаал огт мэдээлээгүй;
- Дундговь аймгийн МЭГ 123.3 сая төгрөгийн гүйлгээ бүрэн байршуулаагүй;
- Мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан Өвөрхангай аймгийн МЭГ 22, Орхон аймгийн МЭГ 158, Хөвсгөл аймгийн МЭГ 4;

4.4.2 Судалгааны үр дүн

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээнд МЭЕГ-ын орон тоог ХХААХҮСайдын тушаалаар 1189 орон тоогоор баталсан бөгөөд МЭЕГ-ын дарга бүтэц орон тоог шинэчлэн батлаагүй байна.
- Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлыг МЭЕГ-ын даргын 2025 оны А/371 дугаар тушаалаар нэг хүнд хоол /32.0 мянган/ төгрөг, унаа /3.0 мянган/ төгрөг байхаар баталсан байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төлөвлөгөөг нийт 16,572.4 сая төгрөгөөр баталж, 15,895.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн мал эмнэлгийн газрууд дотоод журмыг үндэслэн тухайн төсөв захирагчийн шийдвэрээр 10.0-28.0 мянган төгрөгийн хооронд баталсан байна.

- Гадаад томилолтын 17 арга хэмжээнд 259.7 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 14 арга хэмжээнд 224.9 сая төгрөг зарцуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн. Завсрын аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэлийг тодорхойлж аудитын ерөнхий стратегийг боловсруулсан. Завсрын аудитаар 546.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, асуудлын бүртгэлээр баталгаажуулж ажилласан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.1 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 5 албан шаардлага, 4 зөрчилд зөвлөмж өгснийг 100.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 10. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	1,966.0	5	1,966.0	100.0
Зөвлөмж	4	192.4	4	192.4	100.0
Нийт дүн	9	2,158.4	9	2,158.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Их хэмжээний өр төлбөр, авлага үүсгэж байгаа асуудлыг анхаарах, Төсвийн шууд захирагчдыг арга зүйгээр хангаж, санхүүгийн сахилга баттай ажиллах талаар зөвлөмж өгч хэвших.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 1,930.5 сая төгрөгийн 29 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Санхүүгийн аудитаар нийт 18,667.0 сая төгрөгийн 85 зөрчил² илэрснээс, 51.6 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоож, 17,868.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 31 албан шаардлага хүргүүлж, 746.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 34 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 18,667.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 25 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 21 байгууллагад бие даасан дүгнэлт гаргаж, 4 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна. Харьяа 17 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 4 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 6,683.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,930.5 сая төгрөгийн 29 алдааг аудитын явцад залруулж, 51.6 сая төгрөгийн 20 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,955.3 сая төгрөгийн 29 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 746.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 30 зөвлөмжийг өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн асуудлаар нийт 11,055.2 сая төгрөгийн 17 зөрчил илэрснээс 788.6 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10,266.5 сая төгрөгийн 14 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нийт 13,913.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйн улмаас тайлант онд 13,913.6 сая төгрөгийн авлага, 31,589.3 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заалсантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн, санхүүгийн сахилга батыг сайжруулж, их хэмжээний авлага, өр төлбөр үүсгэж байгаа зөрчлийг арилгах.

Илрүүлэлт-2: "МЭЭГ-ын харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 15,138.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 1,930.5 сая төгрөгийн 29 алдааг аудитын явцад залруулж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

залруулагдаагүй санхүүгийн тайлангийн 4,753.4 сая төгрөг, нийцлийн аудитын асуудлаарх 11,055.2 сая төгрөг, нийт 15,808.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 51.6 сая төгрөгийн 20 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,743.9 сая төгрөгийн 32 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11,013.0 сая төгрөгийн зөрчилд 44 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Энэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд болон хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй, нэгдсэн арга зүй, заавар зөвлөмж сул байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6 дугаар зүйлийн 6.6.1-д "Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаарх нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн сахилга батыг сайжруулж, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Стратеги төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мал эмнэлгийн салбарын стратеги, бүтэц зохион байгуулалттай холбоотой дараах асуудал байна.

- Мал эмнэлгийн салбарын 2025-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 тоот тушаалаар байгуулсан боловч стратеги төлөвлөгөөг батлуулаагүй;
- Салбарын сайдын 2025 оны А/548 тоот тушаалаар МЭЭГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай тушаал гарсан боловч байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн батлаагүй, Чиг үүргийн шинжилгээ хийлгэж ажлын байрны ачааллыг жигдрүүлэх талаарх Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна" Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралт "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.3-т "Яамны харьяа агентлаг нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан салбарын сайдаар, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг аймаг, нийслэлийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д "Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Стратеги төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, Төрийн албанаас өгсөн чиглэлийн хүрээнд чиг үүргийн шинжилгээг хийж бүтэц орон тоог шинэчлэн батлах.

2. Батлагдсан төсөвтэй холбоотой

Илрүүлэлт: Батлагдсан төсвийг хуваарилахдаа Төсвийн шууд захирагч бүрээр албажуулж, /батлав иж бүрдэл хангаагүй/, баталгаажуулж төсвийн захирагч нарт хүргүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр эдийн засгийн ангилал, хүрэх үр дүнгийн хамт баталж, төсвийн захирагч нарт хүргүүлж хэвших.

3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Салбарын үндсэн үйл ажиллагаатай холбоотой тухайлбал Жил бүр давтагдах шинж чанартай дархлаажуулалтыг зохион байгуулах гэх мэт байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг харьяа 22 байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлж төсвийн үндсэн зарчмыг алдагдуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, бие даасан, нэгдмэл байдлыг хангах"; 5.1.2-т "Мал эмнэлгийн үйлчилгээг энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан тэгш, хүртээмжтэй хүргэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Салбарын үндсэн үйл ажиллагаа болох дархлаажуулалтын үйлчилгээний хөлсийг харьяа байгууллагуудын үндсэн дансаар батлагдсан төлөвлөгөөний дагуу олгож хэвших.

4. Төлөвлөгөө тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын "нэгдсэн төлөвлөгөөг" гаргаж хэвшээгүй, өвчин тус бүрээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Энэ нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Эрсдэл ихтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан энэ хуулийн 28.9-д заасан зөвлөлөөр хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг хуульд заасан орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	2	10,540.0		-	2	10,540.0	2	10,540.0		
2	Архангай аймгийн Мал эмнэлгийн газар	1	489,557.9			1	489,557.9	1	489,557.9		
3	Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газар	4	567,645.9		-	4	567,645.9	4	567,645.9		
4	Булган аймгийн Мал эмнэлгийн газар	2	78,023.8			2	78,023.8	2	78,023.8		
5	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	1	352,349.8			1	352,349.8	1	352,349.8		
6	Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газар	1	14,420.0			1	14,420.0	1	14,420.0		
7	Дархан аймгийн Мал эмнэлгийн газар	1	14,546.7			1	14,546.7	1	14,546.7		
8	Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар	6	55,886.5	1	4,394.1	5	51,492.4	6	55,886.5		
9	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар	2	17,967.0	1	13,612.9	1	4,354.1	2	17,967.0		
10	Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар	1	11,658.2			1	11,658.2	1	11,658.2		
11	Ховд аймгийн Мал эмнэлгийн газар	2	11,519.4			2	11,519.4	2	11,519.4		
12	Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар	1	1,679.4			1	1,679.4	1	1,679.4		
13	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	3	299,445.8			3	299,445.8	3	299,445.8		
14	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	2	5,313.3			2	5,313.3	2	5,313.3		
НИЙТ ДҮН		29	1,930,553.7	2	18,007.0	27	1,912,546.7	29	1,930,553.7		

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл								Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Нийт зөрчил		Үүнээс						Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
A	Б	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ	6	13,913,638.5			2	13,913,638.5	4	-				
2	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	19	3,819,486.4	1	3,180.0	12	3,797,023.8	6	19,282.6				
3	Нийслэлийн мал эмнэлгийн газар	5	7,000.0					5	7,000.0				
4	Архангай аймгийн МЭГ	1	19,500.0			1	19,500.0						
5	Баян-Өлгий аймгийн МЭГ	3	527,833.5	1	1,586.3			2	526,247.2				
6	Булган аймгийн МЭГ	10	89,975.7	6	24,160.1	2	13,115.6	2	52,700.0				
7	Баянхонгор аймгийн МЭГ	2	606.0	1	606.0	1	-						
8	Говь-Сүмбэр аймгийн МЭГ	4	49,366.9	1	204.8	2	43,532.0	1	5,630.1				
9	Дархан аймгийн МЭГ	1	801.6			1	801.6						
10	Дорнод аймгийн МЭГ	1	100.0	1	100.0								
11	Дорноговь аймгийн МЭГ	5	22,054.3	2	9,704.8	1	4,157.0	2	8,192.5				
12	Дундговь аймгийн МЭГ	3	3,219.0	2	1,110.9	1	2,108.1						
13	Завхан аймгийн МЭГ	2	11,195.5	1	2,924.0			1	8,271.5				
14	Орхон аймгийн МЭГ	3	8,973.0	1	5,190.0	1	3,783.0	1	-				
15	Өмнөговь аймгийн МЭГ	1	4,575.4			1	4,575.4						
16	Сүхбаатар аймгийн МЭГ	3	91,313.9					3	91,313.9				
17	Төв аймгийн МЭГ	4	48,216.0			3	28,216.0	1	20,000.0				
18	Ховд аймгийн МЭГ	4	11,296.1	1	1,559.0	1	7,406.5	2	2,330.6				
19	Хөвсгөл аймгийн МЭГ	1	1,466.4					1	1,466.4				
20	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	4	28,894.6	1	616.0	1	28,278.6	2	-				
21	МЭЭСБУЛ	3	7,546.4	1	639.0	1	2,835.0	1	4,072.4				
	НИЙТ ДҮН	85	18,667,059.1	20	51,580.8	31	17,868,971.1	34	746,507.2				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчлийн дүн		Үүнээс:						Хариуцлага тооцуулах албан шаардлага	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Нийслэлийн мал эмнэлгийн газар	2	2,593,485.2			1	39,000.0	1	2,554,485.2		
2	Баян-Өлгий, Мал эмнэлгийн газар	1	776,973.6					1	776,973.6		
3	Булган, Мал эмнэлгийн газар	3	9,300.0					3	9,300.0		
4	Говь-Сүмбэр, Мал эмнэлгийн газар	2	1,748.0					2	1,748.0		
5	Дорнод, Мал эмнэлгийн газар	1	749,654.2			1	749,654.2				
6	Дорноговь, Мал эмнэлгийн газар	1	-					1	-		
7	Дундговь, Мал эмнэлгийн газар	1	123,371.5					1	123,371.5		
8	Орхон, Мал эмнэлгийн газар	1	-					1	-		
9	Өвөрхангай, Мал эмнэлгийн газар	1	-					1	-		
10	Өмнөговь, Мал эмнэлгийн газар	1	-					1	-		
11	Увс, Мал эмнэлгийн газар	1	6,800,701.1					1	6,800,701.1		
12	Хөвсгөл, Мал эмнэлгийн газар	1	-					1	-		
13	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	1	-			1	-				
	НИЙТ ДҮН	17	11,055,233.6			3	788,654.2	14	10,266,579.4		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1057/A0161027

Улаанбаатар хот

САГ-2026/07/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүйн улмаас тайлант онд 13,913,638.596.00 /Арван гурван тэрбум есөн зуун арван гурван сая зургаан зуун гучин найман мянга таван зуун ерэн зургаа/ төгрөгийн авлагатай, 31,589,329.436.00 /Гучин нэгэн тэрбум таван зуун наян есөн сая гурван зуун хорин есөн мянга дөрвөн зуун гучин зургаан/ төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга батыг сайжруулаагүй, их хэмжээний авлага, өр төлбөр үүсгэдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх), Ерөнхий нягтлан бодогч (С.Угтахбаяр) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
П.БАТЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 6-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264 30

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-7.Docx

1526191328



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 2058 /А0161024

Улаанбаатар хот

САТ - 2026/07/НА - САТ - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа 25 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 17,739,207.900.00 /Арван долоон тэрбум долоон зуун гучин есөн сая хоёр зуун долоон мянга есөн зуу / төгрөгийн 125 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 1,930,553.700.00 /Нэг тэрбум есөн зуун гучин сая таван зуун тавин гурван мянга долоон зуу/ төгрөгийн 29 алдааг аудитын явцад залруулж, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 4,753,420,600.00 /Дөрвөн тэрбум долоон зуун тавин гурван сая дөрвөн зуун хорин мянга зургаан зуу/ төгрөгийн 79 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 11,055,233,600.00 / Арван нэгэн тэрбум тавин таван сая хоёр зуун гучин гурван мянга зургаан зуу/ төгрөгийн 17 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд болон хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй, нэгдсэн арга зүй, заавар зөвлөмж сул байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6 дугаар зүйлийн 6.6.1-д " Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлдэггүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх), Ерөнхий нягтлан бодогч (С.Угтахбаяр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
П.БАТЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-7.Docx

1526181623